

## ЭНЭТХЭГИЙН ФИЛОСОФИ ДАХЬ "МАЙЯ" ХЭМЭЭХ ОЙЛГОЛТЫН ОНТОЛОГИ АГУУЛГА

Б.Мөнхжавхлан (Докторант)

МУИС. НШУС.

Философийн Тэнхим

**Түлхүүр үг:** майя, бодит байдал буюу брахман, атман, материаллаг ертөнцийн харьцангуй шинж, авидья буюу мунхаг байдал

Энэтхэгийн философийн хамгийн гол ойлголтуудын нэг болох болох майя<sup>1</sup> танин мэдэхүй, метафизикийн аль ч онолын хүрээнд яригддаг. Метафизикийн хувьд философийн чиглэлүүд ахуй буюу бодит байдлыг тодорхойлохдоо бүтээгч, өөрөөсөө бүгдийг төрүүлэгч, өөрөө юунаас ч үл хамааран орших, төгс брахманаар илэрхийлдэг. Харин материаллаг ертөнц бол түүний бүтээсэн зүйл бөгөөд брахманаас шууд хамааралтай, бас төгсгөлт шинжтэй, бодитой бус ажээ. Энэхүү бодит хийгээд бодит бусыг ялгах нь онтологи гол асуудал юм.

Харин танин мэдэхүйн хувьд бодгаль хүн бодит, төгс брахман хийгээд төгс бус материаллаг ертөнцийн ялгааг эс таньж, материаллаг ертөнцийг бодитой хэмээн эндүүрч байдаг. Энэ эндүүрлийг арилгаж, бодит байдлыг танин мэдэх зайлшгүй хэрэгцээ бий. Иймийн тулд мэдлэг олж авах гол хэрэгслийг (прамана)<sup>2</sup> ашиглан бодит байдлыг танин мэднэ. Харин энд философийн сургууль бүр онтологи баримтлалаасаа үүдэн танин мэдэхүйн хэрэгслийг ялгаатайгаар чухалчлан авч үзсэн байдаг. Тухайлбал энэтхэгийн материалист философи Чарвака Локоятад материаллаг ертөнцийг бодитой хэмээн үзэж, пратьякша буюу хүртэхүйг тус материаллаг ахуйг танин мэдэхүйн гол хэрэгсэл гэдэг бол ньяя чиглэл, брахманыг бодитой хэмээгээд анумана буюу оюун дүгнэлтийн мэдлэгийг бодит байдлыг танин мэдэх хамгийн гол арга хэмээн үзсэн байдаг юм.

Дээрх онтологи, эпистемологийн асуудлаас үүдэн цаашид ёс зүй, шашны үзэл баримтлалуудад холбон үзэх боломжтой. Учир нь бодит байдлыг танин эс мэдсэнээс үүдэж зовлон эхлэх бөгөөд хүний амьдралын гол зорилго бол зовлонгийн буюу мунхагийн хүлээснээс ангижирч гэгээрэх явдал юм гэж энэтхэгийн философийн чиглэл бүр үздэг. Энэхүү зовлонгийн үг шалтгааныг мунхаг байдал хэмээн үзнэ. Энэтхэгийн философийн үүднээс авч үзвэл ертөнцөд 1. Майя нь "төөрөгдөл", "хуурмаг үзэгдэл" гэсэн утга бүхий санскрит үг бөгөөд энэтхэгийн философид хэд хэдэн утгаар тайлбарлагддаг. Эхний утга нь тэрээр брахманы үйлдэх хүчийг илэрхийлнэ. Бүхнийг бүтээгч, бүхнийг мэдэгч брахманы бие даан оршиж эс чадах материаллаг юмсыг бүтээх чадварыг ийнхүү нэртэдэг. Дараагийн утга нь эгэл хүний хийж эс чадах юмсыг чадах бурхан, чөтгөрийн чадварыг хэлнэ. Ихэвчлэн Шакти буюу эм хүч гэдэг бөгөөд зарим философид Шива, Вишну бурхны дагуул гэж үздэг. Майя ухамсарт хийгээд ухамсаргүй бүх юмсын харагдах байдлыг илэрхийлдэг бөгөөд брахман түүгээр дамжуулж материал юмсыг бүтээдэг. Харин мокша буюу гэгээрэл, чөлөөлөгдсөн байдалд хүрэхийн тулд майя буюу төөрөгдлийг арилгах ёстой. Веданта философид майя хэмээх энэ ойлголтыг хязгааргүй брахман өөрийгөө хязгаарлагдмал ертөнцөөр илэрхийлэх космик хүч гэж үздэг.

2. Энэтхэгийн философид танин мэдэхүүд 3 зүйлийг онцолно. Эдгээр нь прамата-танин мэдэгч субъект, прамья-танин мэдэгдэгч объект, прамана буюу танин мэдэхүйн эх сурвалж юм. Пратьякша буюу хүртэхүй, анумана буюу оюун дүгнэлт, упамана буюу харьцуулалт, шабда буюу итгэмжийн мэдлэг, артхапатти буюу таамаглал, анулабдхи буюу эс оршихуй гэсэн 6 төрлийн танин мэдэхүйн хэрэгсэл байдаг.

хүн гурван төрлийн зовлонд автаж байдаг. Зовлон нь:

1. Би-ээс (өөрөөс) ба сэтгэлээс үүдэх зовлон
2. Байгаль буюу гадаад ертөнцийн хүчин зүйлээс үүдэх зовлон
3. Далдын хүчин зүйлээс (гариг эрхэс, сүнс, ад чөтгөр) холбоотой үүдэх зовлон гэсэн гурван төрөл бий.

Ниймээс хүн эдгээр зовлонгоос ангижирахыг эрмэлзэх бөгөөд үүний тулд мунхагаас ангижрах ёстой юм. Өөрөөр хэлбэл зөв танин мэдэхүйн үрээр мунхагийг гэтэлнэ гэсэн үг ажээ. Энэхүү өгүүллийн гол зорилго онтологи асуудал болох бодит байдлын талаархи зарим агуулгыг илэрхийлэх учир ёс зүйд холбогдох агуулгыг үүгээр өндөрлөө.

Дээр дурдсанчлан энэтхэгийн философийн дийлэнх чиглэлүүд бодит байдлыг брахманаар тодорхойлдог. Энд нэг зүйлийг зориуд онцолж хэлэхэд брахман, атман хэмээх хоёр ойлголтыг хамтатган авч үзнэ<sup>3</sup>. Зарим Упанишадад эдгээр ойлголтыг адил утгаар хэрэглэсэн байдаг.

Тухайлбал, Брахадараньяка Упанишадад ертөнц бол атман, “би” биш харин майя бөгөөд энэ нь авидья буюу мунхагтай холбоотой үүсдэг гэжээ. Үүнтэй адил санаа Ригведийн дуулуудад өгүүлэгдсэн бөгөөд тэнд оршихуйн нэгдмэл байдлыг онцолсон байна. Юмсын урсах, цувирах байдал, шалтгаан үр дагаварын бие биеэсээ уялдаат, хамааралтай байдал энэ бүхэн нь жинхэнэ бодит байдал биш юм гэдэг.

Жишээ нь, Ригведэд өгүүлэгдсэнээр “яруу найрагч нэг зүйлд маш олон нэр өгдөг” гэсэн нь плюрал байдал бол зөвхөн үгнээс хамааралтай гэдгийг харуулж байна. Бусад дуулуудад мөн плюрал байдал гэдэг нь бодит ахуй биш, энэ бол нэгдмэл байдал гэсэн юм.

Энэ мэт санаа өрнөдийн философид бий. Эртний Грекийн философич Парменид, эмпирик бодит байдал бол зөвхөн харагдаж буй зүйл гэж үзэж байсан бол Платон хэлэхдээ, эмпирик бодит байдал нь зөвхөн бодит байдлын сүүдэр, тусгал төдий юм гэсэн байдаг. Энэ нь Упанишадын агуулга, Грекийн дээрхи сэтгэгчдийн санаанд адил төсөө байгааг харуулж байна.

Тухайлбал Кант: ертөнц гэдэг нь бидний мэдэж байгаагаар зөвхөн харагдах байдал. Энэ бол бодит байдал биш юм. Ертөнцийн юмс зөвхөн феномен буюу үзэгдэл бөгөөд бидний ухамсарт цаг хугацаа орон зайн хүрээнд орж ирдэг. Гэхдээ эдний бие даасан бодит оршихуй нь бидний ухамсраас ангид байгаа юм. Харин бид түүнийг өөрсдийн ойлголт, хүртэхүйгээрээ хэлбэржүүлж байдаг гэсэн билээ.

Упанишадуудад бодит байдал буюу ахуйг тайлбарлахдаа майя хэмээх ойлголтыг авч үздэг. Олон философи, шашин, энэхүү веданта философийн үзэл баримтлалд тодоор тусгагдсан трансцендент үнэнийг танин мэдэхийн тулд майя-ийн уг чанарыг мэдэх ёстой гэсэн санааг Упанишадаас уламжлан авч хэрэглэсэн байна.

Энэхүү ойлголт Ригведэд 70 удаа, Атхарва Ведад 27 удаа дурдагдсан<sup>4</sup> гэж үздэг. Хуурмаг, зэрэглээ, ид шид гэсэн утга мөн бий. Эртний Ведийн утга зохиолд Варунагийн хүчийг майя гэж нэрлэсэн байна. Бас Агни, Индра бурхдын хүчийг ч мөн ингэж нэрлэжээ. Пурана, Вайшнавын теологи сургаалд майя-ыг Вишнугийн 9 шактигийн нэг гэж үздэг. Бас Шветашватара Упанишадад практиктэй адилтгасан байдаг.

Энэтхэгийн философийн гол чиглэл болох Ведантад үзэхдээ бодит байдал бол цор ганц

3. Брахман бол ахуй буюу бодит байдал бөгөөд харин атман нь ахуйн ухамерын талыг илэрхийлдэг. Зарим Упанишадад брахман бол универсал сүнс, ертөнцийн сүнс гэдэг бол атманыг бодгалийн сүнс гэж тайлбарласан байдаг. Ингэж үзсэний гол шалтгаан нь бодгаль бүрт бодит байдлыг танин мэдэх бололцоо бий бөгөөд танин мэдсэний үр дүнд брахманд нэгдэнэ, брахман болно хэмээн үзэнд оршино. Ингэснээр жинхэнэ ахуй, жинхэнэ “би”-г нээх боломж бий гэдгийг утга юмс цор ганц бодит байдал гэсэн санааг анзаарч болох юм.

4. <http://www.esamskriti.com/essay-chapters/Appearance-and-Reality.aspx>

брахман бөгөөд материаллаг ертөнц бол хуурамч зүйл, бодит байдлыг өнгөлөн далдлагч юм гэж үздэг. Харин тэр хуурмаг материаллаг ертөнц нь угтаа брахманы хүч болох майя-аас үүдэж байдаг гэдэг.

Энэтхэгийн философид бодит байдал, үнэн, бурхан, брахман, "Төгс Би" гэсэн ойлголтууд адил утгатай. Ведантын сургаал ёсоор орчлонгийн үнэн гэдэг бол цор ганц үг эсхүл ойлголтоор илрэхгүй бөгөөд үүнийг энгийн оюун ухаанаар ч тодорхойлж боломгүй юм. Нэгэнт брахман мөнх байх цор ганц үнэн учир түр зуурын зүйл бол үнэн биш юм. Майя-аас үүдэж материал ертөнц бий болдог бөгөөд энэ ертөнц байгаа нь үнэн авч брахмантай харьцуулбал үнэн биш юм.

Хүний оюун ухаан, туршлага гэдэг угтаа үнэний нэгээхэн хэсэг ажээ. Бодгальд өөрт нь брахмантай нэгдэх, брахман болох бололцоо бий гэсэн санаа энд байгааг харж болно. Энэ философи уламжлалын үздэгээр бол оюун ухааны объектийг абсолют үнэнээс ялгаатай авч үзэх хэрэгтэй. Иймээс бодгаль "би"-г универсал, "Төгс Би"-д нэгтгэх нь бол хүний амьдралын эцсийн зорилго юм.

Адвайта Веданта философийн хувьд майя бол хязгаарлагдмал, цэвэр физикийн шинжтэй бөгөөд бидний ухамсартай холбоотой зүйл юм. Бидний ухамсар л майя-ын хүчээр, түүний ид шидэд автаж материал ертөнцийг, цувиралт юмсыг үнэхээр байна хэмээн үздэг. Майя бол үзэгдлийн харагдах байдал юм. 419

Нөгөөтэйгүүр майя бол хуурамч зүйл биш. Эндээс харвал бодит байдал гэдэг нь брахман, майя хоёр хоёулаа юм. Гэхдээ энд майя, авидья, брахманыг адилтгаж болохгүй. Бүтээгч чадавхи, брахманыг далдлах чадвартайг нь эерэг, харин ухамсрыг төөрөгдүүлж байдгаар сөрөг утгаар ойлгох нь зохистой билээ. Гэгээрлийн гол зорилго бол энэхүү брахман хийгээд майя-ийг ялгах явдал мөн. Ер нь энэхүү ялгааг танин мэдэхэд майя аяндаа үгүй болно. Майя-г тодорхойлогдошгүй гэдэг. Майя-д хоёр гол үүрэг бий. Нэг нь авъякта, энэ нь брахманыг бидний ухамсраас нууж байдаг. Харин нөгөө нь парамешашакти бөгөөд материаллаг ертөнцийг нээн харуулж байдаг юм.

Адвайта философийн гол сэтгэгч Шанкарачарья майя-г тодорхойлж хэлэхдээ:

1. "Төгс Би" буюу бодит байдал бол "Би" өөрийгөө ухамсарласан байдал юм.
2. Энэ нь эр эм хоёр зарчимтай.
3. Аз жаргалын туршлагаас "Төгс Би" бий болох бөгөөд энд гүн нойрсож буй мэт байна. Майя энд нойрон дундах зүүд мэт байдаг. Учир нь зүүд нойронд юмс бий болж бодитой мэт байдаг.
4. Энэхүү майя нь бодит хийгээд бодит бус байдлын ямарваа шинжийг агуулдаггүй. Эхлэлгүй бөгөөд "Төгс Би"-ээс шалтгаалдаг.
5. Мөн хөдөлдөг хийгээд эс хөдөлдөг юмс бүхий орчлонгийн гурван гуна (сагтва, ражас, тамас) буюу чанарыг хэлбэржүүлдэг.
6. Майя бол харагдаж үзэгдэшгүй. Түүнийг мэдрэхүйгээр хүртэж болохгүй. Гэвч хэрхэн харагддаггүй юмс харагддаг юмсыг бүтээх вэ гэсэн асуулт гарна. Тодруулж хэлбэл хэрхэн утас нэгдэж хувцас бий болдог вэ гэсэн асуулт жишээ байна. Тэгэхээр утас өөрөөсөө хувцсыг бүрдүүлэх чадавхитай. Нэг талаас энэ нь бүтээгч зарчим болж байна.
7. Майя-г хүртэж үл болох бөгөөд гэгээнтнүүд хүртэл анхааралтайяа судлахад аянга цахилгаан мэт хормын зуур үгүй болно. Энэ нь майя үнэхээр бодитой оршин байдаггүйг илэрхийлж байна.
8. Майя бодит байдал буюу брахман, авидья буюу мунхагтай холбоотой. Авидья нь бодгалийн ухамсраас хамааралтай байна. Бодгалийн ухамсар бодит байдлыг танин мэдэх бололцоотой гэжээ.

Харагдах ертөнц бол брахманаас шууд хамааралтай. Харин брахман юунаас ч хамааралтай бус. Харагдах байдлын шалтгаан бол майя бөгөөд бодит байдлыг танин мэдсэн үед майя үгүй болно. Хэрэв майя бодит байдал болох брахманыг нууж, материаллаг ертөнцийг бодитой хэмээн харуулдаг юм бол эндээс яагаад төгс, дээд брахман төгс бус майя-аар дамжуулан ертөнцийг бий болгодог вэ гэсэн асуулт гарна.

Ведантистууд үүний хариуд хэлэхдээ энэ бол хүний туршлагад хамаарна гэсэн. Бодит байдлыг танин мэдээгүй мунхаг байдалтай холбоотойгоор бид бодитой хийгээд бодит бусыг ялгаж чаддаггүй. Ийм мунхаг байдлаас үүдэж л бид юмсыг байгаа мэтээр үзэж, хууртаж байдаг ажээ. Энэ мунхаг байдал бол авидья юм. Майя сагтва гунаас тогтдог бол, авидья сагтва, ражас, тамас гурвуулангаас нь тогтоно.

Угтаа майя, авидьяг бас адил шинжүүдээр нь харьцуулж үзэж болно. Майя, авидьяд байх адилтгах шинжийг Шанкарачарья дараах байдлаар мөн илэрхийлжээ.

1. Майя, авидья нь материаллаг, ухамсаргүй. Цэвэр ухамсар брахманы эсрэг ойлголт.
2. Майя, авидья нь брахманы дотоод чадавхи. Брахманаас салгаж үзэх боломжгүй.
3. Майя, авидьяд эхлэл гэж үгүй.
4. Майя, авидья нь бодит байдлыг нууж байдгаараа негатив бол, брахманы шинжийг юмсын ертөнцөөр дамжуулан илэрхийлж байдгаараа позитив.
5. Майя, авидья нь тодорхойлогдошгүй юм. Энэ бол дан ганц брахманаас үүдэлтэй болохын хувьд бодитой биш, гэхдээ харагдах ертөнцийг илэрхийлж байдгаараа бодитой.
6. Майя, авидья нь феноменал бас харьцангуй шинжтэй. Энэ бол зөвхөн харагдах байдал.
7. Майя, авидья нь адхьяса буюу хэтийдүүлэн оноосон байдал юм. Олсыг могойтой адилтгахтай адил буруу танихуй.
8. Майя, авидьяг зөвхөн зөв мэдлэгээр л арилгаж болно. Бодит байдлыг танин мэдсэн үед мунхаг байдал үгүй болж, олсыг могойтой андуурах явдалгүй болно.
9. Майя, авидья нь брахманаас хамааралтай бөгөөд илбэчин өөрийн илбэнд хууртдаггүйн адил брахман эдгээрийн нөлөөнд автдаггүй.

Шанкарьачарья өөрийн философи үзэлдээ харагдах байдлын гол шалтгаан майя-г зөв мэдлэгээр арилгаж болно. Энэ бол бодитой ч биш, бодитой бус ч биш юм.

Яагаад төгс брахман, төгс бус ертөнцийг бүтээнэ вэ? Энэ бол хүний бодит хийгээд бодит бусыг ялгах чадвар дутаж байгаагаас хамаарч байгаа юм. Хүн л бодит бусыг бодитой гэж, би бишийг, “би” гэж андуурч байдаг. Жишээ нь, би сайхан, би муухай, би тарган, би туранхай гэх мэт нь нэг зүйлийг л нэлээд олон янзаар илэрхийлж буйн хэрэг юм. Майя байгаагийн бас нэгэн зорилго бол бурхны төлөөх бидний сэтгэлийг идэвхжүүлэхэд зориулагдана. Тэр байснаараа хүн ахуйн бодит байдлын хувьд төөрөгдөлд орж, түүнээс ангижрах, танин мэдэх, итгэх гэх мэт идэвхтэй үйлийг хийж байдаг. Угтаа бидний хийгээд бодит байдал хоёрын хооронд орших гол зүйл бол майя юм.

Майя-ийн талаар арамбхавада, паринамавада гэсэн хоёр үндсэн үзэл бий. Арамбхавада-энэ бол бүтээгчийн тухай үзэл юм. Бүтээгч бол бүгдийг бүтээгч, буй бүхний анхдагч шалтгаан, эх сурвалж байдаг.

Харин паринамавада үзэхдээ бүх юмс бол цор ганц бурхны өөрчлөлт, хүч чадлын илэрхийлэл гэсэн байна. Өөрөөр хэлбэл бүгдэд бурхан бий гэсэн пантейст, мөн материйн хувьсал өөрчлөлт гэсэн санаа байна. Упанишадад ер нь энэхүү майя хэмээх ойлголтын талаар теологи, космогони, идеалист байр сууринаас авч үзсэн олон янзын үзэл баримтлал байдаг

бөгөөд тэдэнд нийтлэг агуулагддаг гол санаа бол майя бол брахманы өөрийгөө илэрхийлэх хүч хийгээд хүн танин мэдэхүйн алдаа төөрөгдлөөс ангижирч чөлөөлөгдсөн байдалд хүрэх хамгийн гол зорилго юм гэсэн байдаг. Философийн энэ чухал ойлголтоос үүдэж энэтхэгийн философийн сургуулиуд онтологийн үзэл баримтлалаа боловсруулан хөгжүүлсэн байна.

### НОМ ЗҮЙ

1. Max Muller. *Upanishads*. Wordsworth Editions. 2001 (first 1884).
2. Paul Deussen. *The philosophy of the Upanishads*. Delhi., 2005
3. S.Radhakrishnan, C.A. Moore (eds.) *A source Book in Indian Philosophy*, Princeton, Princeton University Press. (1989)
4. S.Radhakrishnan. *Indian philosophy*, I volume, London., 2008
5. A.A.Macdonell. *A Vedic reader for students*. Delhi., 2002
6. <http://www.esamskriti.com/essay-chapters/Appearance-and-Reality.aspx>

### SUMMARY

*The concept of maya is fundamental to Indian philosophy. To liberate from this world of suffering, one must remove his or her ignorance. Samkara, one of the great thinkers of Indian philosophy says identifies that maya is illusion as well as avidya. Therefore, to apprehend the genuine reality that is Brahman, maya must be removed. It is the cardinal principle of reasoning and aim of life according to teaching of Indian thought.*